

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/32/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024      Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор:              Б.Цэрэнчимэд Утас: 99890393      Цахим хаяг: <a href="mailto:tserenchimedb@audit.gov.mn">tserenchimedb@audit.gov.mn</a> Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	12
3.Аудитын тайлан .....	12
3.1. Ерөнхий зүйл .....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	16
Аудитын зөвлөмж .....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал.....	16
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯН-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ Г  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.ЦЭЦЭГЖАРГАЛ  
ТАНАА

2021. 02.25 № 2/144  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажилласан байна.

Тус байгууллага нь ковид-19 цар тахал онцгой дэглэмийн үед аймаг, сумын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

• 005020122

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>80,673,642.00</u></b>	<b><u>97,937,802.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	9,950,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	9,950,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	9,950,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	80,673,642.00	87,987,802.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	00.00	712,650.00
35130	Эм боох материал	00.00	712,650.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	80,673,642.00	87,275,152.00
35410	Бичиг хэргийн материал	1,801,750.00	1,692,380.00
35420	Аж ахуйн материал	2,215,700.00	4,666,500.00
35440	Түлш, шатах тослох материал	99,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	9,370,000.00	5,876,300.00
35460	Хүнсний материал	3,521,840.00	366,420.00
35470	Бусад хангамжийн материал	63,665,352.00	74,673,552.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,480,620,657.03</u></b>	<b><u>1,429,050,628.89</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,480,620,657.03	1,429,050,628.89
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,464,024,657.03	1,412,454,628.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,453,632,729.64	1,464,064,429.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-67,585,000.30	-137,269,170.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	176,290,265.00	124,006,817.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-142,185,653.76	-92,429,968.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,906,271.00	72,022,450.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,476,273.09	-44,054,068.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,630,248.00	11,630,248.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,531,896.46	-9,770,075.60
39217	Ном	21,343,967.00	24,253,967.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	16,596,000.00	16,596,000.00
39301	Програм хангамж	500,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,596,000.00	16,596,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,561,294,299.03</u></b>	<b><u>1,526,988,430.89</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,561,294,299.03</u></b>	<b><u>1,526,988,430.89</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,561,294,299.03	1,526,988,430.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	280,983,355.00	280,983,355.00
51101	Өмч: - төрийн	280,983,355.00	280,983,355.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	72,569,345.01	38,263,476.87
51210	Өмнөх үеийн үр дүн	72,569,345.01	72,569,345.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-34,305,868.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,207,741,599.02	1,207,741,599.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,561,294,299.03</u></b>	<b><u>1,526,988,430.89</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,075,355,375.00</b>	<b>841,306,075.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>284,360,175.00</b>	<b>4,586,352.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	284,360,175.00	4,586,352.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	284,360,175.00	4,586,352.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	284,360,175.00	3,586,352.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>141,930,900.00</b>	<b>114,706,423.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	649,064,300.00	722,013,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,025,700.00	22,224,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,674,960.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,025,700.00	9,549,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	137,905,200.00	92,395,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	137,905,200.00	92,395,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00.00	86,263.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	86,263.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>828,210,457.74</b>	<b>875,611,943.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>828,210,457.74</b>	<b>875,611,943.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	774,450,531.74	823,716,497.14
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	474,941,092.00	531,005,349.00
210101	Үндсэн цалин	474,941,092.00	531,005,349.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,922,129.00	67,679,946.00
210201	Тэтгэврийн даатгал	40,825,385.00	46,326,853.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,802,986.00	5,450,217.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,811,668.00	4,319,853.00
210204	Ажилгүйдлийн даатгал	952,918.00	1,053,001.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,529,172.00	10,530,022.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	106,876,033.00	88,096,582.00
210301	Гэрэл, цахилгаан	2,908,742.00	1,811,843.00
210302	Түлш, халаалт	103,727,291.00	86,044,739.00
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	240,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,067,088.00	13,053,120.00
210401	Бичиг хэрэг	1,892,350.00	2,397,570.00
210402	Тээвэр, шатахуун	3,666,330.00	5,173,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,765,750.00	1,259,700.00

**Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210404	Ном, хэвлэл	166,800.00	117,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	54,000.00	483,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,620,000.00	1,739,200.00
210408	Бараа материал акталсны зардал	10,901,858.00	1,881,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>17,678,640.00</b>	<b>14,016,960.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	547,730.00	786,490.00
210502	Хоол, хүнс	17,130,910.00	13,230,470.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,942,600.00</b>	<b>11,342,700.00</b>
210604	Урсгал засвар	3,942,600.00	11,342,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,948,000.00</b>	<b>1,949,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,948,000.00	1,949,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,707,500.00</b>	<b>2,068,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,307,500.00	1,618,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>84,367,449.74</b>	<b>94,504,140.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,398,320.00	1,397,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,333,440.00	481,760.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,635,689.74	92,625,280.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53,759,926.00</b>	<b>51,895,446.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,604,013.00</b>	<b>25,761,123.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	86,263.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,891,400.00	11,382,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,674,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,712,613.00	1,617,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>24,629,267.00</b>	<b>5,933,618.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,529,267.00	1,384,118.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>526,646.00</b>	<b>20,200,705.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	526,646.00	20,200,705.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>247,144,917.26</u></b>	<b><u>-34,305,868.14</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>534,647.61</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	534,647.61	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-534,647.61</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>246,610,269.65</u></b>	<b><u>-34,305,868.14</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>793,044,295.00</b>	<b>837,719,723.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	1,000,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>793,044,295.00</b>	<b>836,719,723.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	649,064,300.00	722,013,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	649,064,300.00	722,013,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,025,700.00	22,224,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,674,960.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,025,700.00	9,549,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	137,905,200.00	92,395,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	137,905,200.00	92,395,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	2,049,095.00	86,263.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,049,095.00	86,263.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>793,044,295.00</b>	<b>800,250,823.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>793,044,295.00</b>	<b>800,250,823.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>737,235,274.00</b>	<b>748,355,377.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	474,941,096.00	531,005,350.00
210101	Үндсэн цалин	379,100,896.00	377,181,749.94
210102	Нэмэгдэл	57,119,400.00	78,261,520.84
210104	Урамшуулал	38,720,800.00	75,562,079.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,922,125.00	67,679,945.00
210201	Тэтгэврийн даатгал	42,160,625.00	46,647,160.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,440,300.00	5,338,209.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,552,400.00	4,246,906.00
210204	Ажилгүйдлийн даатгал	888,000.00	1,040,787.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,880,800.00	10,406,883.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	106,876,033.00	88,096,582.00
210301	Гэрэл, цахилгаан	2,908,742.00	1,811,843.00
210302	Түлш, халаалт	103,727,291.00	86,044,739.00
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	240,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,137,240.00	11,539,950.00
210401	Бичиг хэрэг	2,362,860.00	2,209,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,666,330.00	5,173,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,765,750.00	1,259,700.00
210404	Ном, хэвлэл	3,543,300.00	145,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	483,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,619,000.00	2,267,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,393,820.00	13,667,990.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	537,280.00	1,805,140.00

**Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210502	Хоол, хүнс	17,711,540.00	10,075,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,145,000.00	1,787,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>38,573,900.00</b>	<b>10,999,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	2,920,000.00
210602	Тавилга	12,250,000.00	00.00
210604	Урсгал засвар	17,323,900.00	8,079,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,948,000.00</b>	<b>1,949,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,948,000.00	1,949,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,006,600.00</b>	<b>2,497,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,606,600.00	2,047,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,436,460.00</b>	<b>20,920,560.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,999,320.00	2,079,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,437,140.00	18,841,460.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,809,021.00</b>	<b>51,895,446.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,653,108.00</b>	<b>25,761,123.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,049,095.00	86,263.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,891,400.00	11,382,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,674,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,712,613.00	1,617,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>24,629,267.00</b>	<b>5,933,618.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,529,267.00	1,384,118.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>526,646.00</b>	<b>20,200,705.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	526,646.00	20,200,705.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>37,468,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>37,468,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>37,468,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>37,468,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	37,468,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-37,468,900.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280,983,355.00	1,207,741,599.02	-174,040,924.64	1,314,684,029.38
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	280,983,355.00	1,207,741,599.02	-174,040,924.64	1,314,684,029.38



Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,394,649.37	2,394,649.37
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>280,983,355.00</b>	<b>1,207,741,599.02</b>	<b>72,569,345.01</b>	1,561,294,299.03
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>280,983,355.00</b>	<b>1,207,741,599.02</b>	<b>72,569,345.01</b>	1,561,294,299.03
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>280,983,355.00</b>	<b>1,207,741,599.02</b>	<b>72,569,345.01</b>	1,561,294,299.03
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-34,305,868.14	-34,305,868.14
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>280,983,355.00</b>	<b>1,207,741,599.02</b>	<b>38,263,476.87</b>	1,526,988,430.89

## **2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	815,170,800.00	793,824,177.00	21,346,623.00	97.4
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	815,170,800.00	793,824,177.00	21,346,623.00	97.4
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	794,620,700.00	780,824,277.00	13,796,423.00	98.3
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	532,457,900.00	531,005,350.00	-1,452,550.00	99.7
Үндсэн цалин	389,192,900.00	377,181,749.94	12,011,150.06	96.9
Нэмэгдэл	67,743,900.00	78,261,520.84	10,517,620.84	115.5
Урамшуулал	75,521,100.00	75,562,079.22	40,979.22	100.1
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,026,400.00	67,679,945.00	-1,346,455.00	98.0
Тэтгэврийн даатгал	47,300,000.00	46,647,160.00	-652,840.00	98.6
Тэтгэмжийн даатгал	5,431,600.00	5,338,209.00	-93,391.00	98.3
ҮОМШӨ-ний даатгал	4,345,200.00	4,246,906.00	-98,294.00	97.7
Ажилгүйдлийн даатгал	1,086,400.00	1,040,787.00	-45,613.00	95.8
Эрүүл мэндийн даатгал	10,863,200.00	10,406,883.00	-456,317.00	95.8
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	89,157,500.00	88,096,582.00	-1,060,918.00	98.8
Гэрэл, цахилгаан	2,872,700.00	1,811,843.00	-1,060,857.00	63.1
Түлш, халаалт	86,044,800.00	86,044,739.00	-61.00	100.0
Цэвэр, бохир ус	240,000.00	240,000.00	0.00	100.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,457,700.00	14,449,950.00	-1,007,750.00	93.5
Бичиг хэрэг	2,210,000.00	2,209,900.00	-100.00	100.0
Тээвэр, шатахуун	5,178,000.00	5,173,400.00	-4,600.00	99.9

**Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,259,700.00	1,259,700.00	0.00	100.0
Ном, хэвлэл	3,056,400.00	3,055,200.00	-1,200.00	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	484,000.00	483,950.00	-50.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,269,600.00	2,267,800.00	-1,001,800.00	69.4
<b>Нормативт зардал</b>	19,677,100.00	13,667,990.00	-6,009,110.00	69.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,818,300.00	1,805,140.00	-13,160.00	99.3
Хоол, хүнс	16,028,100.00	10,075,050.00	-5,953,050.00	62.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,830,700.00	1,787,800.00	-42,900.00	97.7
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,531,500.00	35,529,100.00	-2,400.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	7,150,000.00	7,148,400.00	-1,600.00	100.0
Тавилга	8,890,000.00	8,890,000.00	0.00	100.0
Урсгал засвар	19,491,500.00	19,490,700.00	-800.00	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	1,969,200.00	1,949,000.00	-20,200.00	99.0
Дотоод албан томилолт	1,969,200.00	1,949,000.00	-20,200.00	99.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,690,900.00	1,644,000.00	-46,900.00	97.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,240,900.00	1,194,000.00	-46,900.00	96.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	0.00	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29652500.00	26802360.00	-2,850,140.00	90.4
Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	2,200,100.00	-2,799,900.00	44.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,652,500.00	24,602,260.00	-50,240.00	99.8
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20550100.00	12999900.00	-7,550,200.00	63.3
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,550,100.00	12,999,900.00	-7,550,200.00	63.3
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,920,100.00	11,382,300.00	-7,537,800.00	60.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,630,000.00	1,617,600.00	-12,400.00	99.2
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	815,170,800.00	793,824,177.00	21,346,623.00	97.4
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	722,013,300.00	701,812,595.00	20,200,705.00	97.2
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	722,013,300.00	701,812,595.00	20,200,705.00	97.2
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	92,157,500.00	91,011,582.00	-1,145,918.00	98.8
Орон нутгийн төсвөөс	92,157,500.00	91,011,582.00	-1,145,918.00	98.8
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0

005 ТОРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	47.00	46.00	-1.00	97.9
Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	33.00	32.00	-1.00	97.0
Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00	100.0
<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	430.00	419.00	-11.00	97.4
<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	430.00	419.00	-11.00	97.4
Төрийн өмчит ЕБС	430.00	419.00	-11.00	97.4

## **2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Цэцэгжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 08-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 68 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш бүр ажлын байрандаа тасралтгүй хөгжиж хэрэгцээт хөтөлбөр боловсруулан суралцагчдын сурлагын амжилт чанар, сурах арга барилд ахиц гарган, сурах хөгжих таатай орчин бүрдүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль



- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 600578.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12011.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 875611.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 17512.2 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1526988.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 34305.9 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	80,673.6	97,937.8	17,264.2
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	9,950.0	9,950.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	80,673.6	87,987.8	7,314.2
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,480,620.7	1,429,050.6	(51,570.0)
Үндсэн хөрөнгө	1,738,899.5	1,712,873.9	(26,025.6)
Хуримтлагдсан элэгдэл	(258,278.8)	(283,823.3)	(25,544.5)
<b>Нийт хөрөнгө</b>	1,561,294.3	1,526,988.4	(34,305.9)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,561,294.3	1,526,988.4	(34,305.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,561,294.3	1,526,988.4	(34,305.9)

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Өмнөх онд авлагагүй байсан бөгөөд тайлант онд 9950.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Санко Маркетинг Монголия ХХК-руу ухаалаг самбарын үнэ 9950.0 мянган төгрөг шилжүүлээд хөрөнгийг аяагүй байгаа тул авлагаар бүртгэжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 87987.8 мянган төгрөг болж 7314.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эм боох материал 712.6 мянга, аж ахуйн материал 2450.8 мянга, бусад хангамжийн материал 11008.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж бичиг хэрэг 109.4 мянга, түлш шатах тослох материал 99.0 мянга, барилгын засварын материал 3493.7 мянга, хүнсний материал 3155.4 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1712873.9 мянган төгрөг болж 26025.6 мянган төгрөгөөр буурсан нь 66179.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 701.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, 200.0 мянган төгрөгийн программ хангамж акталж, данснаас хассан, төсвийн хөрөнгөөр 34468.9 мянга, хандив бусад эх үүсвэрээр 3586.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 2020 онд төсвийн хөрөнгөөр барилга байгууламжид 88м 4576,0 мянган төгрөгийн сургуулийн хашаа, 14 нэр төрлийн 13895.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 20 нэрийн 13818.0 мянган төгрөгийн тавилга, 61 нэрийн 2910.0 мянган төгрөгийн ном худалдан авсан, үндсэн хөрөнгө нийт дүнгээрээ 41055.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, аймгийн ИТХТ-ийн хурлын 2020.07.06-ны 12 дугаар тогтоолоор тавилга эд хогшлын 3 нэрийн 701.8 мянга, 2 нэрийн 66179.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, нийт 67080.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1426628.3 мянган төгрөг болж 319131.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 319131.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 841306.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 234049.3 мянган төгрөгөөр буюу 21.8 хувиар буурсан байна.

Үүнд үнэ төлбөргүй авсан орлого 280773.8 мянга, орон нутгийн санхүүжилтийн орлого 45509.5 мянган төгрөгөөр тус тус бууч, зориулалтын шилжүүлэг 72949.0 мянга, туслах үйл ажиллагааны орлого 1000.0 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 18198.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлжээ.



Нийт зардал 875611.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 47401.5 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал 63822.1 мянга, эд хогшил урсгал засварын зардал 7400.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 10136.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 18779.4 мянга, хангамж бараа материалын зардал 7013.9 мянга, нормативын зардал 3661.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 2638.8 мянган төгрөгөөр тус тус буурсан нь голлох нөлөө үзүүлжээ

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 851686.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 851686.7 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

Тайлант онд дээрх төсөвт 4 удаа зохицуулалт хийж, 36515.9 мянган төгрөгөөр бууруулж, 815170.8 мянган төгрөгөөр баталжээ.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 851686.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж 4 удаа тодотгол хийн 815170.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 722013.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 92157.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 92395.7 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 722013.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 793824.2 мянган төгрөгийг зарцуулж 21584.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 793824.2 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 2799.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1060.8 мянга, хангамж бараа материалын зардлыг 1007.7 мянга, нормативд зардлыг 6009.1 мянга, эд хогшил урсгал засварын зардлыг 2.4 мянга, албан томилолтын зардлыг 20.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 46.9 мянга, бараа үйлчилгээний зардлыг 2850.1 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 7550.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71802 хөтөлбөрийн 80109 арга хэмжээ 1060.9 мянга, 80802 арга хэмжээ 12.4 мянга, 81801 арга хэмжээ 7537.8 мянга, 81806 арга хэмжээ 6135.0 мянга, 8134 арга хэмжээ 5222.6 мянга, 81835 арга хэмжээ 1034.1 мянга, 71806 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 343.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ДҮН</b>		<b>815,170.8</b>	<b>793,824.2</b>	<b>21,346.6</b>	<b>97.4</b>
<b>Хөтөлбөр 71802</b>	Баян-өндөр сумын Цэцэрлэг	805,274.1	784,271.3	21,002.8	97.4
Арга хэмжээ 80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	92,157.5	91,096.6	1,060.9	98.8
Арга хэмжээ 80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,630.0	1,617.6	12.4	99.2
Арга хэмжээ 81801	үдийн цай хөтөлбөр	18,920.1	11,382.3	7,537.8	60.2
Арга хэмжээ 81806	Дотуур байрны үйлчилгээ	77,476.6	71,341.6	6,135.0	92.1
Арга хэмжээ 81834	Боловсролын стандарт, сургалтыг хэвийн явуулах үйчилгээ	464,528.4	459,305.8	5,222.6	98.9
Арга хэмжээ 81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	150,561.5	149,527.4	1,034.1	99.3
<b>Хөтөлбөр 71806</b>	Насан туршын болон албан бус боловсрол	9,896.7	9,552.9	343.8	96.5
Арга хэмжээ 80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	9,896.7	9,552.9	343.8	96.5

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 22224.4 мянган төгрөгийн орлого төвлөрч, 5 жилийн тэтгэмжид 12674.9 мянга, бараа материалын үнэд 853.0 мянга, Баян-Өндөр хоршоонд 2869.0 мянган төгрөг шилжүүлж, гал тогооны ширээ, хөргүүр, вакум хаалт, хаалга зэргийг худалдан авсан байна.

Үзүүлэлт	орлого	зарлага	үүнээс		
			5 жилийн тэтгэмж	материалын үнэ	хөрөнгө бэлтгэсэн
5 жилийн тэтгэмж	12,674.9	12,674.9	12,674.9		
Эрдэнэмонгол ХХК хандив	5,000.0	4,147.0			4,147.0
модны үнэ	4,549.5	853.0		853.0	
Үлдэгдэл төвлөрүүлсэн		4,549.5			
<b>Нийт дүн</b>	<b>22,224.4</b>	<b>22,224.4</b>	<b>12,674.9</b>	<b>853.0</b>	<b>4,147.0</b>

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 1 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага тогтоогоогүй, зөвлөмж өгөгдөөгүй

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайланд алдаа, зөрчил илрээгүй, шилэн дансны мэдээлэлд 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. /Хавсралт 1./

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар санхүүгийн тайланд алдаа, зөрчил илрээгүй, шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой 1 зөвлөмж өглөө.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

2.2.Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

2.3.Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу мэдээллийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

2.4.Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Б.ЦЭРЭНЧИМЭД 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.25



### 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо</b>	<b>Аудитын нэр:</b>	Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b>
2020			БНА-2021/57/СТА-ТШЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс Шилэн дансны мэдээллийн Төсөв, гүйцэтгэл талбарт сар бүр оруулах 1, тухай бүр оруулах 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	0	зөвлөмж	Захирал, нягтлан бодогч	Д.Цэцэгжаргал, З.Саранчулуун
<b>ДҮН</b>		0			

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_